Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 9,012,275.9 мянган төгрөг болж оны эхний үлдэгдэл 44,961.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Энэ нь тайлант онд байгууллагын төсвийн хөрөнгөөр 78,426.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, аймгийн ИТХ-ын хуралдааны 2023.02.13-ны өдрийн 13/11 дүгээр тогтоол, ТӨБЗГ-ын 2023.11.30-ны өдрийн 623 тогтоолоор 1,801.2 мянган хөрөнгийг үнэ төлбөргүй бүртгэсэн байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023.02.17-ны өдрийн А/ 102 тогтоолоор үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Lexus 470 86-63 БНА 45,110.0 мянган төгрөгийн өртөгтэй авто машиныг аймгийн Орон нутгийн өмчийн газарт балансаас балансад, Lexus 470 26-13 БНА 88,644.0 мянга, HUMMER 04-44 БНР 39,000.0 мянга, Caravan 99-02 БНХ 35,000.0 мянган төгрөгийн өртөгтэй суудлын авто машинуудыг дуудлага худалдаагаар худалдан борлуулж, балансаас хассан байна. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023.11.13-ны өдрийн 108 дугаар “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” тогтоолын дагуу 2021 онд ашиглалтад орсон 121,100.0 мянган төгрөгийн өртөгтэй Toyota land cruiser - J76 маркын 24-99 БНН улсын дугаартай автомашиныг балансаас Жинст сумын ЗДТГ-т шилжүүлсэн байна.

Өглөг: ХХОАТ-ын өглөг 8,542.8 мянган төгрөгийг 2023.12.25-ны өдөр гүйлгээ хийсэн боловч дансанд буцаж орсноор өглөг үүссэн.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,471,100.5 мянган төгрөг болж 91,414.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээр хасагдсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,485,219.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4,485,219.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,230,899.9 мянган төгрөгөөр бууруулж 3,254,319.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2023.07.03-ны өдрийн хуралдааны 15/42 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2023.12.15-ны өдрийн А/680 дугаар захирамжаар Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70106 хөтөлбөрийн 80101, 80112, 80205, 80802, 81102 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,957,366.2 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд орон нутгийн төсвийн санхүүжилтээр 3,857,366.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 57,857.1 мянган төгрөгийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 3,908,888.3 мянган төгрөгийг зарцуулан, 23,142.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,908,888,3 мянган төгрөг буюу 98,9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэлтэй холбоотой зардал 1,924,376,0 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд 225,427,5 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 406,604,1 мянга, тээвэр шатахуун 90,000 мянга, Засаг даргын нөөц хөрөнгө 895,923,5 мянган төгрөг зарцуулсан нь голлох нөлөө үзүүлж байна. Төсвийн хэмнэлт 23,142,6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 746,696.1 мянган төгрөгийн орлогыг Сангийн сайдын 149, 151 дугаар тушаалаар 5 суманд дэмжлэг үзүүлэх 460,000.0 мянган төгрөг, Төрийн албаны салбар зөвлөлийн зардал, Архивын ерөнхий газраас 3 гэрээт ажилтны урамшуулал, “Хүүхдийн спортын наадам”-д дэмжлэг НҮБ-аас, бүрдүүлж, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 746,679.3 мянган төгрөгийг зарцуулж 16.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газраар Шатахуун, бичиг хэрэг нийлүүлэн тендерийг зохион байгуулж, шалгарсан Петровис ХХК-тай шатахуун нийлүүлэх, Дижитал сервис ХХК-тай Бичиг хэрэг хангах гэрээг байгуулан ажилласан.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Аймгийн ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, чанарын хяналтыг газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хэрэгжүүлсэн.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны анхны батлагдсан төсөв 3,783,274.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 37,832.7 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 26,482.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2023 оны Цалин-13,289.8 мянган төгрөг, хэвлэл мэдээллийн зардал 3,000.0 мянга, цэвэр, бохир усны зардлыг 517.7 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

#### **Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг бүрэн оруулсан байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Завсрын аудит Засаг даргын нөөц хөрөнгөтэй холбоотой зөрчил илэрснийг албан шаардлага хүргүүлсэн.

##### **4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, аудитаар нийт 333,638.7 мянган

төгрөгийн зөрчлийг илрүүлж 333,638.7 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 1 зөвлөмж хэргүүлснээс хэрэгжилтийг 2023.06.09-ны өдрийн 2/901 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	333.638.7	3	329,891.1	75%
Зөвлөмж	1	0	1	0	100%
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>333.638.7</b>	<b>4</b>	<b>329,891.1</b>	<b>98.9%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 107,920.0 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>1</sup> илэрснээс 107,920.0 мянган төгрөгийн зөрчил арилгах 4 албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илрүүлсэн 107,920.0 мянган төгрөгийн зөрчлийг материаллаг бус гэж үзсэн тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

#### 5.1 Албан шаардлага

5.2.1 Засаг даргын нөөц хөрөнгөөс 8,110.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийн зардал гарсан.

Энэ нь Төсвийн тухай хууль 6 дугаар зүйлийн 6.4.1”төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 16 дугаар зүйлийн 16.5.5. “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” гэсэн заалттай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмын дагуу зарцуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Засаг даргын нөөц хөрөнгөөс 2 удаагийн захирамжаар Япон улс руу 22,938.1 мянга, Турк улс руу сумдын засаг дарга нарын зардал 52,500.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хууль 6 дугаар зүйлийн 6.4.1”төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 16 дугаар зүйлийн 16.5.5. “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” гэсэн заалтыг зөрчсөн, Сангийн сайдын 3.1.2.урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх; байна

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмын дагуу зарцуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2.3 Засаг даргын нөөц хөрөнгөөс улсын төсвийн байгууллага Прокурорт 20,000.0 мянга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 4,732.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хууль 6 дугаар зүйлийн 6.4.1”төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 16 дугаар зүйлийн 16.5.5. “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” гэсэн заалттай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмын дагуу зарцуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2.4 ГХБХБГ-ын газраас ирүүлсэн судалгаагаар 2023.02.04-ны өдрийн 94 дүгээр захирамжаар олгосон 900 мкв талбайтай газар байгууллагын хөрөнгөд бүртгэлгүй, байгууллагын бүртгэлтэй 2000 мкв талбайтай 2020.04.30-ны өдрийн А/21 захирамжаар олгосон газар тус судалгаанд байхгүй байна.

Энэ нь Нягтлан 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;

Шийдвэрлэсэн нь: Газрын эрхийн гэрчилгээг эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн нягтлан бодох бүртгэлд бүртгэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Үүнээс Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг даргын нөөц хөрөнгөөс 8,110.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийн зардал гарсан.	1	8,110.0			1	8,110.0		
Засаг даргын нөөц хөрөнгөөс 2 удаагийн захирамжаар Япон улс руу 22,938.1 мянга, Турк улс руу сумдын засаг дарга нарын зардал 52,500.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	75,438.1			1	75,438.1		
Засаг даргын нөөц хөрөнгөөс улсын төсвийн байгууллага Прокурорт 20,000.0 мянга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 4,732.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	1	24,372.0			1	24,372.0		
ГХБХБГ-ын газраас ирүүлсэн судалгаагаар 2023.02.04-ны өдрийн 94 дүгээр захирамжаар олгосон 900 мкв талбайтай газар байгууллагын хөрөнгөд бүртгэлгүй, байгууллагын бүртгэлтэй 2000 мкв талбайтай 2020.04.30-ны өдрийн А/21 захирамжаар олгосон газар тус судалгаанд байхгүй байна.	1	0			1	0		
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>107,920.0</b>			<b>4</b>	<b>107,920.0</b>		

-----oOo-----



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 193/А0580 237

Номгон

БНА - 2024/181/НА - СТА - ТУ13

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Үүнд:

Баянхонгор аймгийн Засаг даргын А/567, А/689 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс Япон улс руу 22,938,100.0 (Хорин хоёр сая есөн зуун гучин найман мянга нэг зуу) төгрөг, Турк улс руу сумдын засаг дарга нарын зардал 52,500,000.0 (Тавин хоёр сая таван зуун мянга) төгрөг нийт 75,438.100 (Далан таван мянга дөрвөн зуун гучин найман мянга нэг зуу) төгрөгийг гадаад арга хэмжээнд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хууль 6 дугаар зүйлийн 6.4.1"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5. "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Засгийн газрын 2021 оны 51 дүгээр тогтоол "Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 3.1.2. "Урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, .. тусгахгүй байх." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**


5040768

1. Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмын дагуу зарцуулж, зөрчлийг арилгаж, хэрэгжилтийг нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 06 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн ЗДТГ-ын дарга Д.Энхжаргал ерөнхий нягтлан бодогч С.Гэрэлмаа нарт хариуцуулав<sup>23</sup>.

#### АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>4</sup>:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР :



Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

М.АЛТАНТУЯА

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>3</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 253/А0560 237

Номгон

БНА-2024/181/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор аймгийн Засаг даргын А/207, А/667 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс улсын төсвийн байгууллага Прокурорт 20,000,000.0 (Хорин сая) төгрөг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 4,732,000 (Дөрвөн сая долоон зуун гучин долоо) төгрөг, нийт 24,732,000.0 (Хорин дөрвөн сая долоон зуун гучин хоёр мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хууль 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 16 дугаар зүйлийн 16.5.5. "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Засгийн газрын 2021 оны 51 дүгээр тогтоол "Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1.2 Энэ журмын "урьдчилан төлөвлөж тусгах боломжгүй байсан гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлын төсвийн зардлын зүйл, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

3040771


1. Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмын дагуу зарцуулж, зөрчлийг арилгаж, хэрэгжилтийг нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 06 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн ЗДТГ-ын дарга Д.Энхжаргал ерөнхий нягтлан бодогч С.Гэрэлмаа нарт хариуцуулав<sup>23</sup>.

#### АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>4</sup>:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР :

АХЛАХ АУДИТОР:



Б.МӨНХБАТ

М.АЛТАНТУЯА

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>3</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 251 /А0580237

Номгон

БНА - 2024/181/КА-СА-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Үүнд:

ГХБХБГ-ын газраас ирүүлсэн судалгаагаар 2023.02.04-ны өдрийн 94 дүгээр захирамжаар олгосон 900 мкв талбайтай газар байгууллагын хөрөнгөд бүртгэлгүй, байгууллагын бүртгэлтэй 2000 мкв талбайтай 2020.04.30-ны өдрийн А/21 захирамжаар олгосон газар тус судалгаанд байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 “ бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” заавал бүртгэнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1 Байгууллагын газар эзэмших гэрчилгээний баримт бичгийн зөрчлийг арилгаж, нягтлан бодох бүртгэлд бүртгэн хэрэгжилтийг нотлох баримтыг FAS

5040774

системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 06 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн ЗДТГ-ын дарга Д.Энхжаргал ерөнхий нягтлан бодогч С.Гэрэлмаа нарт хариуцуулав<sup>23</sup>.

#### АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>4</sup>:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР :

АХЛАХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

М.АЛТАНТУЯА

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>3</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 255/А0580237

Номгон

БНА-2024/181/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор аймгийн Засаг даргын А/254, А/631 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс 8,110,000.0 (Найман сая нэг зуун арван мянга) төгрөгийн сэлбэг хэрэгслийн зардал гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хууль 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 16 дугаар зүйлийн 16.5.5. "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Засгийн газрын 2021 оны 51 дүгээр тогтоол "Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1.2 Энэ журмын "урьдчилан төлөвлөж тусгах боломжгүй байсан гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлын төсвийн зардлын зүйл, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмын дагуу зарцуулж, зөрчлийг арилгаж, хэрэгжилтийг нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг

5040777

2024 оны 06 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн ЗДТГ-ын дарга Д.Энхжаргал ерөнхий нягтлан бодогч С.Гэрэлмаа нарт хариуцуулав<sup>23</sup>.


**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>4</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР :

АХЛАХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

М.АЛТАНТУЯА



<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>3</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно